

## Хүүхдийн эмчийн мэргэжлээр эмчлэх зөвшөөрөл олгох шалгалтын жишиг сорил

### Сорил хариулах заавар

1. Нэг сонголттой тест ( Зөвхөн 1 хариулт зөв байх ) Энэ хэлбэрийн сорил нь А, В, С, D, E гэсэн дугаартай бөгөөд Зөвхөн 1 зөв хариуг сонгоно.
  2. Олон сонголттой тест ( Хэдэн ч хариулт зөв байж болох )
    - 1, 2, 3 дугаар хариултууд зөв бол (А.)
    - 1, 2, 3, 4 дугаар хариултууд зөв бол (В.)
    - 2 ба 4 дугаар хариултууд зөв бол (С.)
    - Зөвхөн 4-р хариулт зөв бол (D.)
    - Бүх хариулт зөв бол (E.)
  3. Шалтгаан хамаарлын тест (Заагдсан тестүүдийн үнэн зөв хийгээд тэдгээрийн шалтгаан хамаарлыг тодорхойлно.)
    - Зөв, Зөв, Зөв (А.)
    - Зөв, Зөв, Буруу (В.)
    - Зөв, Буруу, Буруу (С.)
    - Буруу, Зөв, Буруу (D.)
    - Буруу, Буруу, Буруу (E.)
- /1./ Хооллолтын бэрхшээлтэй 4 сартай хүүхдийг өрхийн эмч хэд хоноод үзэх вэ?
- A. 5 хоноод
  - B. 14 хоноод
  - C. 30 хоноод
  - D. 7 хоноод
  - E. 2 хоноод
- /2./ Таталдамхай өвчний анхдагч урьдчилан сэргийлэлтийг зөв сонгоно уу:
- A. Витамин А уулгах
  - B. Кальцийн бэлдмэл өгөх
  - C. Рахитаас сэргийлэх
  - D. Таталт тавиулах бэлдмэл хэрэглэх
  - E. Сийвэнгийн кальцийг тогтмол хянах
- /3./ 8 сартай хүүхэд халуурсан, татсан зовиуртай үзүүлэхэд хүүхдийн халуун 39 хэм, таталт намдсан боловч маш их шаналгаатай, чихнээс булаг гойжоод сар болж байгаа зовиуртай, үзлэгээр чихний ард хүндүүр хавагнасан улайлт байв. Хүүхдийг хэрхэн ангилах вэ?
- A. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний архаг халдвар
  - B. Маш хүнд халууралт өвчин. Чихний архаг халдвар
  - C. Аюултай ерөнхий шинжтэй. Чихний цочмог халдвар
  - D. Маш хүнд халууралт өвчин. Хөхлөг ургацын үрэвсэл
  - E. Маш хүнд халууралт өвчин. Чихний цочмог халдвар.
- /4./ Уушгины гялтангийн хуурай үрэвсэл нь байрлалаасаа шалтгаалан эмнэлзүйн өөр өөр шинжүүдээр илрэнэ. Үүнд:
- A. Өрцний байрлалтай гялтангийн үрэвсэл
  - B. Дэлбэн завсрын гялтангийн үрэвсэл
  - C. Уушгины орой гол хэсгийн гялтангийн үрэвсэл
1. Өвчүү хэвлийгээр өвдөх, юм залгих үед өвдөлт ихсэх
  2. Хавирганы нумаар өвдөх, өрцний хөдөлгөөн багасах
  3. Цээж, хавирга завсраар өвдөх, рентгенд туузан ба зууван сүүдэр үүсэх
- A. A1, B3, C2
  - B. A1, B2, C3
  - C. C1, B2, A3
  - D. A2, B3, C1
  - E. A3, B1, C2
- /5./ Шүүдэст эмзэгшилтэй нярайд ямар шинжүүд илрэх вэ?

- A. Хөлрөмтгий, шилээ шөргөөх, дагзны үс халцрах.
  - B. Нурамтгай, толгойд зузаан хагтай, жин хурдан нэмэгдэх.
  - C. Идээт цэврүүнүүд арьсан дээр гарч халуурах, хөхөндөө дургуйцах
  - D. Гульгимтхай, цочромтхой, нойронд муу.
  - E. Шээх бүр уйлж сэрдэг, шээс нь улаан шар өнгөтэй.
- /6./ Ханиад шуухинаатай хүүхдэд шингэнийг яаж хэрэглэх вэ?
- A. Эрүүл үеийхтэй ижил хэмжээний шингэн өгнө
  - B. Шингэн уух дуршлаас хамаарна
  - C. Эрүүл үеийхээс илүү шингэн өгнө
  - D. Бөөлжиж байгаа үед шингэн өгөхгүй
  - E. Шингэн өгөх шаардлагагүй
- /7./ 4 настай хүүхэд ханиалгасан ба түүний амьсгал 1 минутанд 42 байна. Өөр эмгэг шинжгүй. Та яаж ангилах вэ ?
- A. Уушгины хүнд хатгалгаа буюу маш хүнд өвчин
  - B. Уушгины хатгалгаа.
  - C. Уушигны хатгалгаагүй ханиад шуухнаа.
  - D. Томуу
  - E. Маш хүнд өвчин.
- /8./ Цус багадалттай 1,6 настай хүүхдэд 200 мг төмрийн сульфатыг ямар тунгаар , яаж өгөх вэ?
- A. 1\4 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
  - B. 1\2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
  - C. 1 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
  - D. 1 шахмалаар өдөрт нэг удаа нэг сарын турш.
  - E. 1 шахмалаар өдөрт нэг удаа хоёр сарын турш.
- /9./ Бамбай булчирхайн эрчимжсэн гиперплазийн гол шалтгаан юунд орших вэ?
- A. Бэлгийн боловсролын үе
  - B. Төрөлтийн дараах үе
  - C. Цусан дахь өнчин тархины тиреотропын дааврын хэмжээ нэмэгдэх
- /10./ Хүний оюуны чадавхийн 50% нь хэдэн насанд илэрдэг вэ?
- A. 2 нас
  - B. 3 нас
  - C. 4 нас
  - D. 5 нас
  - E. 6 нас
- /11./ Гаждал цохиулалтын үед хэрэглэх даавар эмчилгээний тунг зөв сонгоно уу:
- A. Преднизолон
  - B. Дексаметазон
  - C. Гидрокортизон
1. 1-2 мг/кг
  2. 5-10 мг/кг
  3. 0.2 -0.4 мг/кг
- A. A1, B3, C2
  - B. A2, B1, C3
  - C. C1, B2, A3
  - D. A2, B3, C1
  - E. A3, B1, C2
- /12./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг- ын шахмалаас яаж өгөх вэ?
- A. 1\4
  - B. 1\2
  - C. 1 бүтнээр
  - D. 1,5
  - E. 2 бүтнээр
- /13./ Тархины хуурай бодисын хэдэн хувийг липид эзэлдэг вэ?

- A. 30%
- B. 40%
- C. 50%
- D. 60%
- E. 70%

/14./ Чихний цочмог халдвартай хүүхдийг 5 хоноод давтан үзэхэд өвдөлт нь ихэссэн, хүүхэд өндөр халуурсан байвал ямар арга хэмжээ авах вэ?

- A. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм өгөөд 2 хоноод давтан үзнэ.
- B. Эмнэлэгт яаралтай хэвтүүлж эмчилнэ.
- C. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эм дээр парацетамолыг нэмж өгнө
- D. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эм, парацетамол өгөөд, чихийг чихээсээр хуурайшуулахыг зааж өгөөд 2 хоноод давтан үзнэ.

/15./ Улаанбурхантай 13 сартай хүүхдэд 50 000 МЕ-тэй А аминдэмийг хэдэн капсулаар өгөх ёстой вэ?

- A. 1 капсул
- B. 2 капсул
- C. 3 капсул
- D. 4 капсул
- E. 5 капсул

/16./ Цус багадалттай 1,6 настай хүүхдэд 200 мг төмрийн сульфатыг ямар тунгаар, яаж өгөх вэ?

- A. 1\4 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- B. 1\2 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- C. 1 шахмалаар өдөрт нэг удаа 14 хоногийн турш.
- D. 1 шахмалаар өдөрт нэг удаа нэг сарын турш.
- E. 1 шахмалаар өдөрт нэг удаа хоёр сарын турш.

/17./ Амьсгалын замыг хэд хуваадаг вэ?

- A. 1
- B. 2
- C. 3
- D. 4
- E. 5

/18./ Нярайн бүтэлтийн үед хүчил шүлтийн тэнцвэр хэд байвал хүндэвтэр гэж үзэх вэ?

- A. pH 7.35-7.45
- B. pH 7.35-7.30
- C. pH 7.30-7.25
- D. pH 7.20-7.10\*
- E. pH 7.10 аас бага

/19./ 3 настай, 12 кг жинтэй хүүхэд 2 хоног суулгасан. Үзлэгээр тайван биш, цочромтгой, арьсны хуниас удаан арилна, шингэн ховдоглон ууна. Хүүхдийг үнэлж ямар арга хэмжээ авах вэ?

- A. Хүнд шингэн алдсан гэж үзээд хураагуур судсанд эхний 1 цагт 30 мл\кг, дараагийн 5 цагт 70 мл\кг жинд тооцоолон Рингер лактатын уусмал юүл.
- B. Шингэн алдсан гэж үнэлээд 400-600 мл ШСД халбагаар уулга.
- C. Шингэн алдсан гэж үзээд 4 цагийн дотор 960-1600 мл ШСД бага багаар уулга.
- D. Хүүхэд шингэн их алдсан тул эмгэлэгт яаралтай хэвтүүлнэ

/20./ 38,5 хэмээс дээш хэлуурч буй 4 настай хүүхдэд парацетамолын 500 мг-ын шахмалаас яаж өгөх вэ?

- A. 1\4 шахмал
- B. 1\2 шахмал
- C. 1 бүтнээр
- D. 1,5 шахмал
- E. 2 бүтнээр

/21./ Таталдамхай өвчний үед огт хэрэглэж болохгүй эмийн бэлдмэлийн зөв сонгоно уу:

- A. Витамин Д

- В. Кальцийн бэлдмэл
- С. Таталт тавиулах бэлдмэл
- Д. Бикарбонат натри
- Е. Антибиотик

/22./ 3 сартай хүүхэд нэг хоног толгойгоо шөргөөж уйлна.Түүний чихэнд хүрэхэд маш их эмзэглэн чанга уйлж байв. Чихний ард хөндүүр хаван байхгүй байна.Өөр шинжүүд илрээгүй. Хэрхэн ангилах вэ?

- А. Рахит
- В. Хөхлөг ургацын үрэвсэл
- С. Чихний архаг халдвар.
- Д. Чихний цочмог халдвар
- Е. Менингит

/23./ Уушгины удамшигч өвчнүүдэд тохирох хамгийн зөв шинжүүдийг уялдуулан сонгоно уу.

- А. Уушгины гемосидероз
- В. Гудпасчерийн хамшинж
- С. Муковисцидоз

1. Уушгийг рентгенд харахад дунд доод хэсгээр толборхог эсвэл торлог сүүдэр харагдана. Зарим үед элэг дэлүү томорч, хурууны үзүүр өргөснө.

2. Цустай цэр гарах, цустай ба уурагтай шээх, цусны шинжилгээнд цус багадалт даамжрах ба рентгенд олон толборхог сүүдрүүд ажиглагдана.

3. Хөлсөнд хлорын хэмжээг тодорхойлоход хэвийнхээс 2-8 дахин ихэснэ

- А. А1, В3, С2
- В. А1, В2, С3
- С. С1, В2, А3
- Д. А2, В3, С1
- Е. А3, В1, С2

/24./ Чихнээс булаг гарч буй хүүхдийн чихийг чихээсээр хэрхэн цэвэрлэх вэ?

А. Чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ, хоногт 3-аас доошгүй удаа чихийг хуурайштал чихээсээр цэвэрлэнэ.

В. Өглөө чихээс хийж орхиод орой чихээсийг шинээр солино.

С. Чихээсийг хоногт 2 удаа хийх ба нийт 5 хоног чихээсээр эмчилнэ.

Д. Чихийг чихээсээр 3 хоног эмчилнэ.

Е. Гидрокортизоны тостой чихээс хийгээд 3 хоног орхино.

/25./ Д аминдэмийн урьдчилан сэргийлэлтийг хүүхдэд хэдийнээс хийх вэ?

- А. 14 хоногтойгоос
- В. 1 сартайгаас
- С. 2 сартайгаас
- Д. 3 сартайгаас
- Е. 4 сартайгаас

/26./ 42 настай өвчтөнд "тиреотоксикозын хүнд хэлбэр" гэдэг онош тавигджээ. Эмчилгээний оновчтой тактикийг заана уу.

А. Яаралтай мэс засал хийх

В. Эмийн хавсарсан эмчилгээ

С. Эмээр эмчлэх, оршин суугаа газраар нь булчирхайн эмч хяналтандаа авах

Д. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг авах

Е. Эмээр эмчлэн, бамбай булчирхайг тайрах

/27./ Тунгалаг эс хэдэн өдөр амьдардаг вэ?

- А. 50-100
- В. 25-50
- С. 100-300
- Д. 10-14
- Е. 7-14

/28./ Шингэн алдалтгүй, цусан суулгалттай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд шингэн алдалтгүй цусан суулгалт намдаагүй, хүүхэд янзандаа байвал ямар арга хэмжээ авах вэ?

А. Котримоксазолыг үргэлжлүүлэн өгөөд 2 хоноод давтан үзнэ.

- В. Эмнэлэгт хэвтүүлж эмчилнэ.  
С. Хоёрдугаар сонголтын үүсгэгчийн эсрэг эм өгөөд 2 хоноод давтан үзнэ.  
D. Хоёрдугаар сонголтын үүсгэгчийн эсрэг эм өгөөд 5 хоноод давтан үзнэ.  
E. Шингэн алдалтгүй тул А төлөвлөгөөгөөр суулгалтыг гэрээр эмчилнэ.
- /29./ Нүдний халдварыг тетрациклины тосоор эмчлэхдээ хоёр нүдийг хэдэн удаа цэвэрлэх ёстой вэ?  
A. 1 удаа  
B. 2 удаа  
C. 3 удаа  
D. 4 удаа  
E. 5 удаа
- /30./ Тураалтай, цус багадалттай, хооллолтын бэрхшээлтэй гэж ангилагдсан 8 сартай хүүхдийг эмч үзэж зөвлөгөө өгөөд, хамгийн ойрын давтан үзлэгийг хэзээ товлох вэ?  
A. 2 хоноод  
B. 5 хоноод  
C. 10 хоноод  
D. 14 хоноод  
E. 30 хоноод
- /31./ Хэрлэгийн үед даавар эмчилгээ хийж буй нөхцөлд дараахыг анхаарна  
1. Калигаар баялаг/төмс, байцаа, жимс, ээдэм/ хоол өгөх  
2. Калийн бэлдмэл нэмж өгөх  
3. Ходоодны үрэвслээс байнга сэргийлэх  
4. Цайрын бэлдмэл өгөх  
5. Харшлын эм хавсран хэрэглэх
- /32./ Хүүхдэд хэдэн янзын үс байх вэ?  
1. Шар үс  
2. Урт үс  
3. Ахар үс  
4. Цагаан үс  
5. Хар үс
- /33./ Нярайг анхны идэвхитэй эргэлтээр өрхийн эмя юу үзэх ёстой вэ?  
1. Эрхтэн тогтолцооны иж бүрэн үзлэг хийнэ  
2. Рефлексүүд үзнэ.  
3. Нярайн зааг шинжүүдийг үзнэ.  
4. Гаж хөгжил буюу стигм байгаа эсэхийг үзнэ.  
5. Төрөлхийн түнхний мултрал ,гилжгий,эвэрхий зэрэг нярай үед энгийн эргээр эмчлэгдэх эмгэгүүдийг хайж үзнэ.
- /34./ Ханиад шуухнаатай хүүхдийг хэзээ яаралтай эргэж үзүүлэхийг зөвлөх вэ?  
1. Халуурах  
2. Өвчин хүндрэх  
3. Амьсгал олшрох.  
4. Амьсгал саадтай болох.  
5. Хөхөндөө буюу хоолондоо муудах
- /35./ Хүүхдийн уушгины үрэвслийн зэрэг, хүндрэлтэй байх эсэх нь дараахаас хамааралтай байдаг:  
1. Үүсгэгчийн хоруу чанар  
2. Эсрэгтөрөгч ба эмгэгтөрөгчийн шинж  
3. Хүүхдийн нас  
4. Амьдралын нөхцөл  
5. Байгал, цаг агаарын нөлөөлөл
- /36./ Улаанбурхан өвчний үндсэн шинжүүдийг нэрлэ:  
1. Бельский-Филатов-Копликийн шинж  
2. Улайх үрэвслийн шинж: ханиах, нүд нуухдах, нус гойжих.  
3. Улайх үрэвслийн шинж эхэлснээс 3-4 хоногт арьсан дээр толбон гүвдрүүт тууралт үе шаттай нарна.

4. Толбон гүвдрүүт тууралт нь хоорондоо нийлэх хандлагатай
  5. Тууралтын 3 дахь өдрөөс нүүрний арьснаас эхлэн арьс гуужин нөсөөжилт үүснэ.
- /37./ Шүүдэст эмзэгшилтэй хүүхдийн эмнэлзүйд эрт илрэх, сэжиглэж болох шинжүүдэд дараах орно:
1. Жин их
  2. Зулайд хаг илрэх
  3. Нурамтгай
  4. Гүвдрүү улайлт, цэврүүт тууралт
  5. Арьс давхайж, хуурайших
- /38./ Ямар үед өтгөн хатах шинж илэрдэг вэ?
1. S гэдэс харьцангуй урт
  2. Хэрэглэж буй хүнсний төрөл
  3. Гэдэсний гажиг хөгжил
  4. Булчин чангарсан үед
  5. Халуурах
- /39./ Нярайн бүтэлтээс сэргийлэхийн тулд дараах арга хэмжээг эрт авах шаардлагатай
1. Жирэмсэн эхийн хяналтыг сайжруулах
  2. Уушгины хөгжил гүйцсэн эсэхийг үнэлэх
  3. Төрлөгийн явцад ургийн зүрхний цохилтыг сайтар хянах
  4. Ургийн эмгэг сул байдлыг /депресс/ эмчлэх
  5. Төрлөгийг зөв удирдах
- /40./ Булган, 28 хоногтой, 3 кг жинтэй, суулгасан гэсэн зовиуртай. Хоногт 8 удаа хөхөө хөхдөг, өөр хоол буюу шингэн өгдөггүй. Суулгаад 15 хонож байгаа. Хүүхэд тайван, нүд хонхоогоогүй, арьсны хуниас хэвийн арилна. Баасанд цусгүй. Өөр эмгэг шинжгүй. Ангил. Эмчил.
1. Шингэн алдалтгүй суулгалт гэж ангилна.
  2. Шингэн алдалтгүй ужиг суулгалт. Хооллолтын бэрхшээлгүй.- гэж анилна.
  3. А төлөвлөгөөний дагуу суулгалт бүрийн дараа 50- 100 мл шингэн уулгана.
  4. Эмнэлэгт хэвтүүлнэ.
  5. 5 хоноод давтан үзнэ.
- /41./ Хүний оюуны чадавхийн 25% нь хэдэн насанд илэрдэг вэ?
1. 1-2 нас
  2. 2-3 нас
  3. 3-4 нас
  4. 4-8 нас
  5. 8-10 нас
- /42./ 11 сартай охин хөхөө хөхөхдөө бага зэрэг хөлөрдөг, гавлын яс зөөлрөөгүй, булчин чанга, сампингийн эрхийн шинжгүй. Өөр өвчний шинжгүй. Эмчид 50000 нэгжтэй Д аминдэм байхгүй байна. Эмч хэрхэн ангилаж ямар арга хэмжээ авах вэ?
1. Рахиттай гэж ангилна.
  2. Рахитгүй гэж ангилна.
  3. Усан Д аминдэм (1 дусалдаа 500 нэгжтэй) 8 дуслаар хоногт нэг удаа нэг сар уулахыг зөвлөнө.
  4. Усан Д аминдэм (1 дусалдаа 500 нэгжтэй) 2 дуслаар хоногт нэг удаа зуны 6,7,8,9 сараас бусад саруудад уулгахыг зөвлөнө.
  5. Усан Д аминдэм (1 дусалдаа 500 нэгжтэй) 2 дуслаар хоногт нэг удаа нэг жил уулахыг зөвлөнө.
- /43./ Гуурсан хоолойн багтрааг дэлхийн олон эрдэмтэд дараахид тулгуурлан ангилдаг
1. Өвчний хэлбэр
  2. Хэвшинж
  3. Хүнд хөнгөний зэрэг
  4. Шалтгаан хамаарал
  5. Хүндрэл
- /44./ Верльгофын өвчний анхдагч сэргийлэлтийг тоочино уу:
1. Архаг голомтыг эмчлэх

2. Ялтсан эсийн тоо, үйл ажиллагааг бууруулах эм хэрэглэхгүй байх\*
  3. Цус гоождог гэр бүлийнхэн удамзүйн эмчээс зөвлөгөө авах
  4. Сарын тэмдгийн үед охид ЕАКК хэрэглэх
  5. Харшилтай тохиолдолд адреналины уусмал тарих
- /45./ Хүүхдийг хэвтээ, босоо, зүүн хажуугаар нь байрлуулж чагнахдаа хаана чагнах вэ?
1. Зүрхний оройн түлхэлтийн хэсэгт
  2. Өвчүүний баруун талд хавирга хоорондын 2-р завсарт
  3. Өвчүүний зүүн талд хавирга хоорондын 2-р завсарт
  4. Өвчүүний дотор 1/3-т аюулхай мөгөөрсний орчим, гол шугамнаас бага зэрэг баруун тийш
  5. Боткины цэгт буюу өвчүүний зүүн талд 3, 4-р хавирга өвчүүнд бэхлэгдэх хэсэгт
- /46./ 2 сараас 5 хүртэлх насны өвчтэй хүүхдийг үнэлж ангилахдаа аюултай ерөнхий шинжүүдээс ямар шинжийг ажиглах ёстой вэ?
1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу
  2. Уусан бүхнээ бөөлжиж байна уу
  3. Хүүхэд татсан уу
  4. Унтаарсан буюу ухаангүй байна уу
  5. Цээж хонхолзож байна уу
- /47./ Уушгины хатгалгаатай 6 сартай хүүхдийг 2 хоноод давтан үзэхэд биеийн байдал нь янзандаа, ханиалгасан хэвээр, амьсгал минутанд 52 байв. Ямар арга хэмжээ авах вэ?
1. Үүсгэгчийн эсрэг нэгдүгээр сонголтын эмийг үргэлжлүүлэн өгнө.
  2. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгнө.
  3. Эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
  4. 2 хоноод давтан үзнэ.
  5. Үүсгэгчийн эсрэг хоёрдугаар сонголтын эмийг өгөөд эмнэлэгт яаралтай хэвтүүлнэ
- /48./ Зүрхний булчингийн үрэвслийн үед эмнэлзүйд илрэх гол шинжүүдийг дурьдана уу.
1. Зүрх зүүн тийш томрох
  2. Зүрхний оройд агшилтын шуугиан
  3. 1-р авиа бүдгэрэх
  4. 1-р авиа эрс тодрох
  5. Зүрхний цохилт цөөрөх
- /49./ ХӨЦМ-ийн дагуу “Уушгины хатгалгаа” гэдэг ангилалтай хүүхдийг эмч гэрээр эмчлэхдээ ямар шинж илэрвэл яаралтай ирж үзүүлэхийг зөвлөх вэ?
1. Уух буюу хөхөндөө муудах
  2. Өвчин хүндрэх
  3. Халуурах
  4. Амьсгал олшрох
  5. Уйлагнах
- /50./ Шээсээр кальци их гарч буй хүүхдэд дараах хүнсний бүтээгдхүүнийг хэрэглэхийг цээрлэнэ
1. Бяслас, ээдэм
  2. Сүү
  3. Тараг
  4. Төмс, байцаа
  5. Тарвас, чангаанз
- /51./ Хэрлэгийн үед бензатинпенициллинG-г тарих зөвлөмжинд дараах орно
1. 27 кг-аас бга жинтэй хүүхдэд 600 000 ед-ээр 21 хоногт 1 удаа
  2. Анхдагч хэрлэг зүрхний үрэвсэлгүй бол 5 жил
  3. 27 кг-аас дээш жинтэй хүүхдэд 1.2 сая ед-ээр 21 хоногт 1 удаа
  4. Анхдагч хэрлэг зүрхний үрэвсэлтэй бол 10 жил
  5. Зүрхний гажиг үүссэн бол 40нас хүртэл тарих
- /52./ Хөхлөг давхаргын онцлог юу вэ?
1. Эс ихтэй
  2. Ээрүүл хэлбэрийн фибробласттай
  3. Гистоцит агуулна

4. Хөөнгө эс ихтэй

5. Идэвхтэй лейкоцит агуулна

/53./ 1нас 4 сартай хүү унтаж байхдаа хөлөрдөг, гавлын яс зөөлрөөгүй, булчин чанга, сарпингийн эрхний шинж илрээгүй. Өөр өвчний шинжгүй. Өрхийн эмчид 50000 нэгжтэй Д аминдэм байхгүй байна. Ээж нь үрлэн Д аминдэм худалдан авсан байна. Өрхийн

1. Рахиттай гэж ангилна

2. Рахитгүй гэж ангилна, нар агаарт гаргахыг зөвлөнө.

3. Рахитгүй тул нар агаарт гаргаж байхад л хангалттай.

4. Үрлэн Д аминдэмээс (50000 нэгжтэй) сард 1 ширхэгээр 6,7,8,9 саруудаас бусад саруудад 2 нас хүртэл уулгахыг зөвлөнө.

5. Д аминдэм давтан уулгах шаардлаггүй

/54./ Ханиалга намдаах хоргүй зөөлөн эмчилгээг дурьд:

1. Хөхний сүү

2. Аньсны ханд

3. Читамон

4. Уротропин

5. Кодеин

/55./ Аденовирусын халдварын үед эмнэлзүйд илрэх онцлох шинжүүдийг зөв сонгоно уу?

1. Нусгайрах, ханиах, хоолой сөөнгөтөх

2. Нүд улайх, нуухтах

3. Гэдэс базалж өвдөх, баас шингэрэх

4. Аденоид ба гүйлсэн булчирхай үрэвсэх

5. Халуурах

/56./ Өрхийн эмч зүрхний гажигтай хүүхдийн зүрхний бүтцийн шуугианыг зүрхний үйл ажиллагааны шуугианаас яаж ялгах вэ?

1. Бүтцийн шуугиан нь тод, ширүүн, удаан сосогдоно.

2. Зүрхний хил хязгаараас гадуур дамжиж сонсогдож болно.

3. Биеийн ачааллын дараа шуугиан ихэсдэг.

4. Биеийн ачааллын дараа шуугиан сулардаг эсвэл арилдаг.

5. Шуугиан зөөлөн, богино сонсогдоно.

/57./ Шүүдэст эмзэгшилтэй хүүхэд дараах онцлогтой

1. Ус давсны солилцоо тогтворгүй

2. Биемахбод ус натрийг барих хандлагатай

3. Хүүхэд хөөнгө, жин ихтэй

4. Шингэн алдах нь хялбар

5. Амархан турах

/58./ Бөөлжилтийг гарлаар нь хэрхэн ангилдаг вэ?

1. Механик

2. Рефлексийн

3. Төвийн

4. Шууд

5. Шууд бус

/59./ Хүнд бүтэлтийн эмнэлзүй дараах шинжүүдээр илрэнэ

1. Амьсгал саадтай буюу амьсгалахгүй

2. Зүрхний хэм 1-д 100-аас

3. Төрсний дараах 1 минутанд Апгарын 0-3 оноотой байх

4. Цочролд хариулна

5. Булчингийн хүчдэл суларсан

/60./ Ганаа 1 нас 2 сартай, 8 кг жинтэй, алга цайсан, Хөхөө хөхөхдөө хөлөрдөг, булчин сул, сарпингийн эрхийн шинжтэй. Хоногт 5 удаа хөхөө хөхдөг, 200 гр бантан, 200 гр каш иддэг, цай боорцогтой 1 удаа иддэг, өөр хоол өгдөггүй. Өөр зовиур ба эмгэг шинжгүй. Ангил. Эмчил. Ямар зөвлөгөө өгөх вэ?

1. Тураал, цус багадалт, рахит, хоололтын бэрхшээлтэй. -гэж ангилна.

2. Өдөрт 5 удаа тусгайлан бэлтгэсэн хоолноос 250-300 мл-ээр идүүлэх. Хөхийг үргэлжлүүлэн хөхүүлэх



3. Д витаминь 50000 нэгжтэй шахмалаас даваа, дүрэв гаригт уулгахаар 7 ширхэгийг ээжид нь өгнө

4. Төмрийн сироп 2 мл буюу хагас цайны халбагаар 14 хоног уулгах.

5. 5 хоноод давтан үзүүл.

/61./ Дархлалын төвийн эрхтэнд ямар эрхтэн хамаарагдах вэ?

1. Аньц булчирхай

2. Фабрициусын хүүдий

3. Чөмөг

4. Дэлүү

5. Тунгалгийн булчирхай

/62./ Хүүхдэд хөхөө зөв үмхүүлж байгааг ямар шинжүүдээр шалгах вэ?

1. Хүүхдийн ам том ангайсан байна.

2. Хүүхдийн доод эрүү хөхөнд хүрсэн байна.

3. Хүүхдийн доод уруул цорвойсон байна.

4. Хөхний толгой ба нөсөөт хэсгийн ихээхэн хэсгийг хүүхэд үмхсэн байна.

5. Хөхний нөсөөт хэсэг хүүхдийн амны дээд талд арай илүү харагдана.

/63./ Гуурсан хоолойн багтраа өвчний шалтгаан

1. Гэрийн тоос

2. Ургамлын тоос

3. Эмийн бодис

4. Хүнсний бүтээгдхүүн

5. Нян

/64./ Верльгофын өвчний үед даавар эмчилгээ хийх заалт:

1. Салстад цус харвалттай түгээмэл тууралт

2. Нойтон хэлбэр

3. Цус алдалтын цус багадалтаар хүндрэх

4. Нүдэнд цус харвах

5. Дотор эрхтэний цус алдалт

/65./ Судасны цохилтыг ямар судсууд дээр тэмтрэх вэ?

1. A. ulnaris

2. A. femoralis

3. A. dorsalis pedis

4. A. radialis

5. Бүгд зөв

/66./ Гуурсан хоолойн багтраа өвчний тавилан дараахаас хамаарна

1. Өвчин эхэлсэн нас

2. Үргэлжилсэн хугацаа

3. Хавсарсан өвчин

4. Хүндрэл

5. Эмчилгээний байдал

/67./ 1 нас 3 сартай тураалтай хүүхэд, хөхөө хөхдөггүй ба өдөрт нэг удаа гурилтай шөлний гурил, шөлийг иддэг. Хүүхэд том хэрчсэн махыг идэхээс дургүйцдэг тул өгдөггүй. 1 удаа үнээний сүүгээр угждаг. Орой гэрийнхнийхээ хоолны шингэн шөлнөөс өгдөг. Хүүхдийг идэвхтэй хооллодоггүй. Энэ хүүхдийн хооллолтын алдаа бэрхшээлүүдийг заа.

1. Хооллолтын тоо цөөн (өдөрт 3 удаа)

2. Хоол нь илчлэг бус /шингэн шөл/

3. Хүүхдийг идэвхтэй хооллодоггүй

4. Хүүхдэд мах идүүлдэггүй

5. Хоногийн хоолны хэмжээ бага

/68./ Зүрхний төрөлхийн гажигтай хүүхдийг мэс засал эмчилгээ хийлгэх хамгийн оновчтой хугацааг зөв тодорхойлно уу.

1. Дөнгөж төрмөгц

2. 3-12 насанд

3. Анхдагч дасан зохицлын үед

4. Харьцангуй дасан зохицлын үед

5. Төгсгөлийн үед
- /69./ ХӨЦМ-ийн дагуу “Ханиад шуухнаа” гэдэг ангилалтай хүүхдэд эмч ямар тусламж үзүүлэх вэ?
1. Халуун сүү, аарц уулгахыг зөвлөнө
  2. Чигатусин, читамон зэрэг хоргүй эмээр ханиадыг гэрээр эмчлэнэ
  3. 30-аас олон хоног ханиалгасан бол онош тодруулахаар эмнэлэг явуулна.
  4. Ямар шинж илэрвал яаралтай ирж үзүүлэхийг эхэд нь хэлнэ.
  5. Хэрэв сайжрахгүй бол 5 хоноод давтан үзүүлэхийг зөвлөнө.
- /70./ Шээсээр нь урат их гарч байгаа хүүхдэд дараах хүнсийг илүүтэй зөвлөнө:
1. Жимс
  2. Хар чавга
  3. Цөцгийн ба ургамлын тос
  4. Гахайн мах
  5. Тарган загас
- /71./ Хэрлэгийн оношлогооны Кисель- Джонсоны эмнэлзүйн туслах шалгуурт орох шинжүүдийг сонгоно уу.
1. Хэрлэгээр өвдөж байсан өгүүлэл
  2. Үеэр хэрж өвдөх, халуурах
  3. Ядрах, хэвлий өвдөх, хамраас цус гарах
  4. Цагираг хэлбэрийн тууралт
  5. Арьсан доорх зангилаа
- /72./ Нярай хүүхдийн арьсны хөрсөн үеийн зузаан хэд байдаг вэ?
1. 0.25-0.36 мм
  2. 0.45-0.65 мм
  3. 0.4-0.7 мм
  4. 0.15-0.25 мм
  5. 0.35-0.55 мм
- /73./ 11 сартай Булган хөхөө хөхөх ба унтаж байхдаа хөлөрдөг, гавлын яс зөөлөрсөн ба булчин сул шинжтэй, сампингийн эрхийн шинж илрээгүй, Өөр өвчний шинжгүй. Өрхийн эмчид 50000 нэгжтэй Д ваминдэм байхгүй байна. Өрхийн эмч хэрхэн ангилаж ямар арга хэмжээ авах вэ?
1. Рахиттай гэж ангилна.
  2. Нар агаарт гаргаж байхыг зөвлөнө.
  3. Усан Д аминдэм (1 дусалдаа 500 нэгжтэй ) 2 дуслаар хоногт 1 удаа зуны 6,7,8,9 сараас бусад саруудад уулгахыг зөвлөнө.
  4. Рахитгүй гэж ангилна.
  5. 50000 нэгжтэй Д аминдэм байхгүй тул зөвхөн нар агаарт гаргахыг зөвлөнө.
- /74./ 2 сараас 5 хүртлэх насны хүүхдэд ямар аюултай ерөнхий шинжийг өрхийн эмч үзлэгийн явцад шалгах ёстой вэ?
1. Хүүхэд уух буюу хөхөх чадвартай байна уу?
  2. Хүүхэд уусан бүхнээ бөөлжиж байна уу?
  3. Хүүхэд татсан уу? Хүүхэд унтаарсан буюу ухаангүй байна уу?
  4. Хүүхэд өндөр халуурах.
  5. Хүүхэд ханиах үедээ бөөлжих.
- /75./ Иж томуугийн үед бага насны хүүхдэд илрэх эмнэлзүйн онцлог шинжүүдийг нэрлэнэ үү.
1. Толгой дух магнай хэсгээр давамгай өвдөх
  2. Өндөр халуурах /39-40 хэм
  3. Үнэр муу мэдрэх
  4. Хоолой сөөж, бачуурах
  5. Тонгойход нүүр чинэрч өвдөх
- /76./ Хүүхэд гэртээ гэнэт нас барахад нөлөөлөх хүчин зүйлүүд.
1. Бүтэлттэй төрөх
  2. Сэрээ булчирхай томтой.
  3. Ходоод улаан хоолойн рефлюкстэй.
  4. Нойрондоо амьсгал нь тасалддаг.

5. Эх нь жирэмсэн байхдаа тамхи, мансууруулах бодис хэрэглэдэг байсан.
- /77./ Шүүдэст эмзэгшлийн жинхэнэ удмын шалтгаантай дархлааны хэлбэр бүхий эмгэгжамд дараах байдал чухал үүрэгтэй:
1. Ходоод гэдэсний саатуулах үйл сул
  2. JgE хэт үүсэх
  3. Хөөнгө эсээс гистамин ихээр ялгарах
  4. Саатуулах эсрэг бие JgG хэт үүсэх
  5. Гистаминаза дутагдалтай
- /78./ Хүүхдийн нарийн гэдэсний онцлог юу вэ?
1. Харьцангуй урт
  2. Салст дотровч нимгэн
  3. Цусны судсаар баялаг
  4. Нас ахих тусам шимэгдүүлэх талбай ихэсдэг
  5. Нарийн гэдэс харьцангуй богино
- /79./ Хүндэвтэр бүтэлтийн эмнэлзүй дараах шинжүүдээр илрэнэ:
1. Амьдралын эхний минутанд амьсгал тогтворжоогүй
  2. Төрсний дараах 1 минутанд Апгарын 4-6 оноотой байх
  3. Цочролд сул хариулна
  4. Зүрхний хэм 1-д 100-аас цөөн
  5. Булчингийн хүчдэл сайн
- /80./ Сэргэлэн 8 сартай, 9 кг жинтэй, 20 хоног суулгасан зовиуртай, өчигдөрөөс баас нь цустай болсон, тайван бус, цочромтгой, шингэн хэвийн ууна, ухаантай, арьсны хуниас хэвийн арилна, нүд хонхоогоогүй. Өөр зовиур ба эмгэг шинжгүй. Ангил. Эмчил
1. Шингэн алдалтгүй ужиг суулгалт. Цусан суулгалт гэж ангилна.
  2. А төлөвлөгөөний дагуу шингэн алдалтаас сэргийлэх эмчилгээ хийнэ.
  3. Ужиг суулгалттай хүүхдийн хооллолтын зөвлөгөө өгөх.
  4. Ципрофлоксацин 15 мг/кг жинд нь тооцон өдөрт 2удаа 3хоног уух.
  5. 2 хоноод давтан үзүүлэх ба хэзээ яаралтай үзүүлэхийг зөвлөнө.
- /81./ Хүүхдийн бөөрний сувганцарт натрийн эргэн шимэгдэлт их байдгаас эдэд хаван хурдан үүсдэг.
- /82./ Хорей өвчний үед албадмал, эмх замбараагүй хөдөлгөөн илэрдэг учраас хүүхэд “сахилгагүй” нэр авдаг.
- /83./ Боталловын цорго гол судасны нумын төгсгөлд цутгадаг учир доод мөч нь дээд мөч, толгойноос хүчилтөрөгчөөр баялаг цусаар хангагддаг.
- /84./ Хүүхдийн булчингийн хөгжил дутмаг байдгаас биеийн цулын харьцаа насанд хүрэгсдийнхээс бага байдаг.
- /85./ Хүүхдийн бөөрний сувганцар, генлийн гогцоо маш богино тул эргэн шимэх үйл дутмаг байдаг.
- /86./ Шингэн их алдалттай үед судсаар сэлбэх нэн тохиромжтой уусмал аль нь вэ?
- A. 10%-ийн глюкозын уусмал
  - B. 5% -ийн глюкозын уусмал
  - C. Рингер Лактатын уусмал
  - D. 10%-ийн NaCl
  - E. физиологийн уусмал
- /87./ ХӨЦМ-ээр ямар насны хүүхдийг нярай хүүхэд гэж тооцдог вэ?
- A. 1 сартай
  - B. 21 хоногтой
  - C. 28 хоногтой
  - D. 2 сар хүртэлх

- Е. 3 сар хүртэлх
- /88./ Аль нь уулгадаг вакцин вэ?
- Сахуу
  - Тавт
  - Саа
  - Улаан бурхан
  - Хөхүүл ханиад
- /89./ Дараах шинжүүдээс аль нь илэрвэл эмнэлэгт яаралтай хэвтүүлэх вэ?
- 14 хоногоос дээш ханиалгах
  - Халуурах
  - Амьсгал олшрох
  - Цустай цэр гарах
  - Чээж хонхолзох
- /90./ Нярай хүүхдийг хэдий үеэс усанд оруулах вэ?
- Хүй цөглөөд 1-2 хоногийн дараа
  - 7 хоногтойгоос
  - 10 хоногтойгоос
  - 14 хоногтойд
  - 1 сартайд
- /91./ Суулгалтын үеийн гэрийн эмчилгээний зарчмыг хэлнэ үү?
- Шингэн илүү уулга
  - Үргэлжлүүлэн хоолло
  - Хэзээ эргэж үзүүлэхийг эхэд зөвлө
  - Цайрын бэлдмэл өг
  - Хоолыг тодорхой хугацаагаар сой
- /92./ Ямар тохиолдолд халууралтыг үнэлэх вэ?
- Халуурсан мэдүүлэгтэй
  - Тэмтрэхэд бий нь халуун
  - Суганы халуун 37.50С
  - Ханиалгасан
  - Суулгасан
- /93./ Рахитыг эмчлэх зорилгоор Д-аминдэмийг яаж хэрэглэх вэ?
- 50000 МЕ буюу 1 капсулыг
  - Даваа, пүрэв гарагуудад
  - Тус бүр 1 капсулаар
  - Нийт 7 ширхэгийг уулгана
  - Зуны улиралд хэрэглэхгүй
- /94./ Халууралтыг хэрхэн үнэлэх вэ?
- Нүднээс нуух гарч байгаа эсэхийг ажиглана
  - Түгээмэл тууралтыг ажиглана
  - Нүдний эвэрлэг бүдгэрсэн эсэхийг шалгана
  - Хүзүүний хөшингийг шалгана
  - Амны шархлааг шалгана
- /95./ Ямар тохиолдолд МАШ ХҮНД ХАЛУУРАЛТ гэж ангилах бэ?
- Хүүхэд амны өргөн гүнгий шархлаатай
  - Хүзүүний хөшингө илэрсэн
  - Хүүхдийн халуун 400С хүрсэн
  - Унтаарсан байдалтай
  - Хүүхэд татдаг
- /96./ Рахитын үед яс зөөлөрснөөс “сампингийн эрхи”-ийн шинж илэрнэ.
- /97./ Хүнд цус багадалтын үед цусны онкос даралт буурснаас гарын алга хувхай цайна.
- /98./ Хүнд тураалын үед өгзөгний өөхлөх арилах учраас “элбэг өмд”-ний шинж илэрнэ.

- /99./ Физиологийн шарлалт нь төрсний дараах 24 цагийн дотор илэрнэ яагаад гэвэл цусанд шууд билирубин ихэснэ.
- /100./ Уушгины хатгалгааны үед уушги хөшүүн болох учраас шуугиантай амьсгалтай амьсгал сонсогдоно.
- /101./ Манай оронд шарилж лууль зэрэг хогийн ургамлын харшлын оргил үе
- 5 сарын 20-доос 7 сарын 30 хүртэл
  - 7 сарын 1-нээс 9 сарын 30 хүртэл
  - 7 сарын 20-доос 8 сарын 30 хүртэл
  - 6 сарын 1-нээс 7 сарын 30 хүртэл
  - 4 сарын 1-нээс 20 хүртэл
- /102./ ГХБ өвчин хамгийн их тархалттай орнуудыг сонго
- Шинэ Зеланд, Англи, Австрали
  - ОХУ, Хятад, Монгол
  - Герман, Австри, Польш
  - Нигери, Чад, Судан
  - Кампучи, Вьетнам, Лаос
- /103./ ГХБ хөдөлсөн үед сальбутамолыг 5 настай хүүхдэд ямар хэмжээгээр өгөх вэ?
- 4 мг-аар өдөрт 3 удаа
  - 2 мг-аар өдөрт 3 удаа
  - 1 мг-аар өдөрт 2 удаа
  - 4 мг-аар өдөрт 4 удаа
  - 3 мг-аар өдөрт 3 удаа
- /104./ Хүүхдэд 6 сартайгаас эхлэн өгч болох II үеийн антигистамины нэр
- Цитеризин
  - Лоратадин
  - Левоцитеризин
  - Дезлоратадин
  - Телфаст
- /105./ Атопийн дерматитэд хэрэглэх кортикостероид тосноос хамгийн сул хүчтэй ангилалд орох тосыг нэрлэ:
- Гидрокортизон
  - Аклометазон
  - Метилпреднизолон(адвантан)
  - Триамценолан ацетонид
  - Бетаметазон валерат
- /106./ Дараах эмүүдээс аль нь нойрсуулах нөлөөгүй вэ?
- Кларотадин
  - Цитеризин
  - Телфаст
  - Левоцитеризин
  - Хлорфенирамин
- /107./ ГХБ өвчний үед шуугиант амьсгал үүсэх механизм
- Гуурсан хоолой өтгөн салсаар бөглөрөх
  - Гуурсан хоолойн гилгэр булчин агчих
  - Гуурсны салст хөөж хавагнах
  - Гуурсан хоолой гаднаасаа дарагдах
  - Гуурсан хоолойд гадны биет орох
- /108./ Харшлын сорилыг ямар үед тавьж болохгүй вэ?
- Халуурч буй үе
  - Харшлын өвчин ид хөдөлсөн үе
  - Биеэр түгээмэл тууралттай үе
  - Гистамин, лейкотриены эсрэг эм уусан үе

5. ДОХ, сүрьеэ
- /109./ Дараах гуурс тэлэгч эмнүүдийн аль нь удаан үйлчилгээтэй вэ?
1. Сальбутамол
  2. Сальметерол
  3. Фенотерол
  4. Формотерол
  5. Ипратропиум бромид
- /110./ Хөхүүл хүүхдийн шүүдэст эмзэгшилд өртөх нь:
1. Гистаминаза ферментийн идэвхи сул
  2. Ийлдэсний бэхлэх чадвар дорой
  3. Карбоксиполипептидаза, моноаминоксидаза, холинэстеразагийн идэвх буурсан
  4. Эдүүд нь гистаминд өндөр мэдрэг
  5. Хөөнгө эсээс их хэмжээний гистамин чөлөөлөх чадвартай
- /111./ Винкристинийг ямар тунгаар хэрэглэх вэ?
- A. 3-5 мг/м<sup>2</sup>
  - B. 1.5-2 мг/м<sup>2</sup>
  - C. 1-2 мг/кг
  - D. 10 мг/кг
  - E. 20 мг/м<sup>2</sup>
- /112./ Гемофили В өвчин хэддүгээр фактор дутагдсанаас үүсэх вэ?
- A. XII
  - B. VIII
  - C. IX
  - D. VII
  - E. X
- /113./ Төлжилтгүйдлийн цус багадалт (гипо, апластик)-ын үед эритроцитын амьдрах хугацаа яаж өөрчлөгдөх вэ?
- A. Бараг 2 дахин багасна
  - B. 4 дахин багасна
  - C. Өөрчлөгдөхгүй
  - D. Бараг 3 дахин богиносно
  - E. 1.5 дахин уртасна
- /114./ Фанконий цус багадалтын үед доорх шинжүүдээс аль нь ховор тохиолдох вэ?
- A. Гиперспленизм
  - B. Микроцефали
  - C. Гипертерми
  - D. Гиперпигментац
  - E. Төрөлхийг гажиг
- /115./ Лейкоз өвчний намжих үеийн шинж тэмдгийг заана уу?
- A. Цусархаг хамшинж, ясны хэмд бласт 5%
  - B. Захын цусанд өөрчлөлтгүй, ясны хэмд бласт 8%, лимфоцит 30%
  - C. Дэлүү том, захын цусанд бласт 1-2%
  - D. Захын цусны үзүүлэлт хэвийн, ясны хэмд бласт 5%, лимфоцит 20%
  - E. Эмнэлзүйн өөрчлөлтгүй, захын цусны үзүүлэлт хэвийн, ясны хэмд бласт 8-10%
- /116./ Гемофилийн үед цус бүлэгнэлтийн хэддүгээр фактор өөрчлөгдөх вэ?
1. VIII
  2. IX
  3. XI
  4. XII
  5. X
- /117./ Лимфогрануломатозын үед гарах эмнэлзүйн шинж тэмдэг
1. Захын тунгалгийн булчирхай нилээд томрох
  2. Шөнө их хөлрөх
  3. Биеийн жин сүүлийн 3-6 сард их алдах
  4. Халуурах

5. Цусархаг хам шинж гарах
- /118./ Төмөр дутагдлын цус багадалтын үед Hb хэмжээ хэдэн г/л-ээс багассан үед улаан эсийн бэлдмэлийг сэлбэх вэ?
1. 41-50
  2. 51-60
  3. 61-70
  4. 40-с бага
  5. 71-с дээш
- /119./ Хамраас цус алдсан үед үзүүлэх яаралтай тусламж
1. Толгой гэдийлгэж хамарт хүйтэн жин тавих
  2. Цус тогтоох уусмалаар норгосон чихээс хийх
  3. Судасны нэвтрэмж багасгах эм хэрэглэх
  4. Цус тогтонгшил сайжруулах эм хэрэглэх
  5. Дааврын бэлдмэл хэрэглэх
- /120./ Шенлейн-Хенохын өвчний үед тууралт ямар онцлогтой вэ?
1. Гар хөлийн 2 талаар тэгш хэмтэй туурна
  2. Дарахад арилахгүй
  3. Тууралт ариласны дараа хөнгөн нөсөө үлдэнэ
  4. Нэг дор янз бүрийн өнгөтэй тууралт ажиглагдана
  5. Тууралт бүх биеэр гарна
- /121./ Цусархаг эмзэгшлийн тууралт ямар онцлогтой вэ
1. Тодорхой шалтгаан нөлөөлсний дараа 1-2 цаг болоод гарна
  2. Тууралт хэдэн өдрөөс хэдэн 7 хоног үргэлжилнэ
  3. Салстуудад тууралт гарах нь элбэг
  4. Тууралт ихэвчлэн загатнана
  5. Ул мөргүй арилна
- /122./ Сийвэнгийн VIII факторын хэмжээ ямар түвшинд хүрэхэд бага зэрэг гэмтлийн дараа цус удаан гоожих вэ?
1. 100-50%
  2. 50-20%
  3. 20-5%
  4. 5-1%
  5. 1-0%
- /123./ Төлжилтгүй цус багадалтын эмнэлзүйн сөрөг гол шинж тэмдэг
1. Цус багадалт
  2. Элэг дэлүү томрохгүй
  3. Цусархаг хам шинж гарах
  4. Тунгалгийн булчирхай томрохгүй
  5. Өндөр халуурах
- /124./ Цус задралын цус багадалтын үед гарах өөрчлөлт нь
1. Эритроцитын амьдрах хугацаа богиносох
  2. Гемоглобины хэмжээ багасах
  3. Ретикулоцитийн тоо ихсэх
  4. Ретикулоцитийн тоо багасах
  5. Эритроцитын амьдрах хугацаа багасах
- /125./ Геморрагический васкулитыг ямар зарчмаар ангилдаг вэ?
1. Үе шат
  2. Идэвхжил
  3. Эмнэлзүйн хэлбэр
  4. Явц
  5. Хүндрэл
- /126./ Элэгний архаг үрэвсэлтэй хүүхэд дараах хоолноос хамгийн тохиромжтойг заа
- A. Сүүтэй будаа
  - B. Цөцгийтэй тараг
  - C. Ээдэм, бяслаг

- D. Үхрийн мах
- E. Тахианы мах

/127./ В төлөвлөгөөгөөр эмчилж буй хүүхэд ууж чадах болмогц ямар шингэнийг ямар тунгаар уулгах вэ?

- A. Физиологийн уусмал 10 мл/кг-д тооцон уулгах
- B. Буцалсан ус хүссэнээр нь уулгах
- C. ШСД-ны уусмал 10 мл/кг-аар цагт тооцож уулгах
- D. ШСД-ны уусмал 5 мл/кг/цагт тооцож уулгах
- E. Мойлны шүүс 5 мл/кг/хоногт тооцож уулгах

/128./ Анхдагч гастрит үүсэхэд хамгийн их нөлөөтэй нь:

- A. Эм байнга уух
- B. Хооллолтын хүчин зүйл
- C. Гэдэсний халдвараар өвчлөх
- D. Эрт унтах
- E. Чихэр их идэх

/129./ Шархлаа өвчний рентген шинжилгээнд шууд илрэх шинж:

- A. Дээд гэдэсний хөдөлгөөн түргэсэх
- B. Шүүрэл ихсэх
- C. Ходоодноос тодосгогч бодис түргэн гарах, хоосрох
- D. Шарх “Ниша” харагдах
- E. Булцуунд зогсонгиших

/130./ Улаан хоолойн үрэвслийг илтгэх хамгийн чухал шинж

- A. Идсэн ууснаараа бөөлжих
- B. Огиулах
- C. Зогисуулах
- D. Өвчүүний араар өвдөх
- E. Турах

/131./ 6 сар хүртэлх насны хүүхдийн жин хоногт хэдэн грамм нэмэгдэж байвал тураалд орохгүй вэ?

- A. 5.0 г
- B. 10.0 г
- C. 15.0 г
- D. 20.0 г
- E. 25-30.0 г

/132./ Аюулхай дор өвдөлттэй үед чанд авианы шинжилгээ, оношилгооны ач холбогдол бага өвчин:

- A. Цэсний хүүдийн хөдөлгөөний хямрал
- B. Цэс чулуужих өвчин
- C. Шархлаа өвчин
- D. Архаг гепатит
- E. Цочмог панкреатит

/133./ Хепатоцитын цитоплазмын сарьс гэмтэхэд ямар фермент ихсэх вэ?

- A. Хүчиллэг фосфатаза
- B. Алат, Асат
- C. Шүлтлэг фосфатаза
- D. Урокиназа
- E. Нуклеаза

/134./ Ходоод-улаан хоолойн сөрөг урсгалыг багасгах нь

- A. Но-шпа
- B. Атропин
- C. Папаверин
- D. Церукал
- E. Анестезин

/135./ Бүдүүн гэдэсний архаг үрэвслийн сэдрэлтийн үед нүүрс-усыг насны хэрэгцээнээс хэдэн хувиар хязгаарлах вэ?



- A. 5%
- B. 10%
- C. 15%-иас илүүгүй
- D. 20%
- E. 30%

/136./ Целиакитай өвчтөнд амьдралын турш үл хэрэглэх бүтээгдэхүүн аль вэ?

- 1. Өөхтэй мах
- 2. Улаан буудай
- 3. Ээдэм
- 4. Арвайн гурил
- 5. Жимсний шингэрүүлсэн шүүс

/137./ Нарийн, бүдүүн гэдэсний үрэвсэлтэй хүүхдийн хоолонд үл хориглох бүтээгдэхүүнийг сонго.

- 1. Утсан, хурц хоол
- 2. Алим
- 3. Өөхтэй мах
- 4. Зуун настын шүүс
- 5. Кока кола

/138./ Гахайн цагаан хорхойн үхрийнхээс ялгаатай шинж

- 1. Умайд нь 30-55000 өндөг агуулагдана.
- 2. Умайд нь 175000 орчим өндөг хадгалагдана.
- 3. Умайн хажуугийн салаалт 8-16
- 4. Умайн хажуугийн салаалт 18-32
- 5. Хоёр эзэнтэй

/139./ Ямар эмгэгийн үед баас сүүний хүчил их агуулсан, дэгдэмхий тосны хүчил ба (pH 3.2-5.2) хүчиллэгээс болж цууны хүчлийн үнэртэй болох вэ?

- 1. Лактозагийн дутал
- 2. Нойр булчирхайн төрөлхийн гипоплази
- 3. Ротавирусийн суулгалт
- 4. Сахароза- изомальтозын дутал
- 5. Цэсний хүчлийн давсны анхдагч бага шимэгдэл

/140./ Хүүхдийн урт аль үед 25 см-ээр нэмэгдэх вэ?

- 1. Тээлтийн эхний 5 сар
- 2. Тээлтийн сүүлийн 5 сар
- 3. Төрсний дараах эхний 1 жил
- 4. Төрсний дараах эхний 6 сар
- 5. Бэлгийн бойжилтын үе

/141./ Буруу хариултыг сонго

- 1. Хялгасан хорхойтох өвчтэй хүүхэд цочромхой ууртай байдаг.
- 2. Хоёр удаа шинжлэхэд өндөг олдохгүй бол хялгасан хорхойтох өвчингүй гэж үзнэ.
- 3. Хялгасан хорхой нэг сар орчмын настай.
- 4. Хялгасан хорхойн эмэгчин 1000 өндөг гаргаад өөрөө үхнэ.
- 5. Хялгасан хорхойтохоос сэргийлэхэд гар угаах чухал.

/142./ Зөв өгүүлбэрийг сонго

- 1. Нярайн ходоодны шүүсний pH-4.0
- 2. Нярайн ходоодны шүүсний pH-6.8
- 3. Нэг настай хүүхдэд ходоодны шүүсний pH-2.0
- 4. Нэг настай хүүхдэд ходоодны шүүсний pH-4.6
- 5. Хүүхдийн ходоодны шүүс насны хамааралгүй

/143./ Бүдүүн гэдэсний шархлаат үрэвслийн хүндэвтэр хэлбэрт илрэх шинж:

- 1. Баасны тоо 4-6 удаа
- 2. Баасанд цусны хольцтой
- 3. Жин ялимгүй буурах
- 4. Хөнгөн цус багадалт
- 5. Өндөр халууралт

/144./ Шингэн алдалтын зэргийг тогтоох үндэслэл нь аль вэ?

1. Нүд хонхойсон
2. Уух дургүй
3. Арьсны хуниас маш удаан арилна
4. Зулай хонхор
5. Хэл ам хуурай

/145./ Өмхий биж ямар хоолноос шалтгаалах вэ?

1. Үнээний цэвэр сүү
2. Ээдэм
3. Мах
4. Өндөг
5. Цөцгий

/146./ Доорхоос аль хэлбэр нь буруу вэ?

- A. Олдмол
- B. Нөлөөллийн
- C. Аяндаа
- D. Хавсарсан ба дан

/147./ Тималиныг 4 настай хүүхдэд ямар тунгаар тарих вэ?

- A. 1 мг
- B. 1,5-2 мг
- C. 2-3 мг
- D. 3-5 мг

/148./ Вискотт-Олдричийн хамшинж нь:

A. 11-р хромосомын хүрээнд хувьсал болсноос генийн согог үүсдэг. T, B эс ба Ig даамжран багасдаг

B. Тунгалгийн эд Ig-ны түвшин хэвийн байдаг боловч CD4 ба CD8-н агууламж эрс багасна.

C. Арьсны атопийн үрэвсэл, дахимтгай халдвар, цус гоожимхой гурвал шинжээр илэрдэг рецессив хэвшинжээр удамшдаг.

/149./ Эх-ихэс-ургаас ялгардаг дархлаа дарангуйлагч хүчин зүйлийг заа?

1. Трофобластын дарангуйлагч хүчин
2.  $\alpha 1$  -фетопротейн
3. Хорионы гонадотропин
4. Прогестрон,
5. ПГЕ-ийн нийлэгжил ихсэх

/150./ Хоёрдогч дархлаа дутал (ХДД)-ын үндсэн шалтгаан юу вэ?

1. Халдвар
2. Бөөрний архаг дутал (БАД)
3. Мэс засал мэдээгүйжүүлэлт
4. Глюкокортикоид, цитостатик эмүүд
5. Зүрхний төрөлхийн хавсарсан гажиг

/151./ Зөв хариултыг заа?

1. IgM, IgA ихсэх нь АГ-ний идэвхжлийг заадаг
2. (Халдвар,хордлого г.м) сөрөг нөлөөллөөс ургийн дархлааны тогтолцоо их эрт сэдээгдэж умайд байхдаа мэдрэгжинэ
3. Нэгэнт АГ-нд мэдрэгжсэн бол өвөрмөц АТ нийлэгжүүлнэ
4. IgM, IgA ихсэх нь ургийн халдварыг нотлох ганц нотолгоо юм
5. Ураг зулбахгүй л бол ДТ бүрэн хөгжинө

/152./ Хүүхдийн физиологийн дархлаа сулралын үед ХДД үүсэх нь амархан ч өвчин хүндэрч ужиграхгүй.

/153./ Тимоцид үүсэхгүй бол Т-лимфоцит үүснэ. Т-эс үүсэж байвал шингэний ДТ хэвийн, учраас дархлаа дуталгүй байна.

/154./ Дэлүү-лимфоцит нөөцлөгдөх гол эрхтэн боловч дархлааны тогтолцоонд үүрэггүй

/155./ Бактериури гэдэг нь:

- A. Эхэн үеийн хөөстэй үнэртэй шээсийг
- B. Давсганд 4 цагаас доошгүй хугацаанд байсан дунд үеийн цэвэр шээс
- C. Лейкоцит 102 дээш байх
- D. Нян 103 дээш байх
- E. Давсганд 4 цагаас дээш хугацаанд байсан шээсэнд нян 105 дээш байх

/156./ Шээс дамжуулах замын халдвар гэдэг нь

- A. Давсагнаас бөөр хүртэлх хаа нэгтээ байгаа халдварыг
- B. Аяганцар тэвшинцэрт байгаа халдварыг
- C. Шээсний сувагт байгаа халдварыг
- D. Шээсний сувгаас бөөр хүртэлх хаа нэгтээ байгаа халдварыг
- E. Түүдгэнцрийн үрэвсэл

/157./ 5 настай охин бүх биеэр хавантай, бөөлжинө, цустай шээнэ, шээсний гарц багассан гэсэн зовуурьтай хэвтжээ. Шинжилгээнд макрогематури, протейнури, азотеми, гипопротейнеми, гипоальбуминеми, гиперлипидеми гарчээ. Энэ өвчин 1 жил үргэлжилж байгаа. Ямар эмгэг байж болох вэ?

- A. Липойдний нефроз
- B. Архаг ГН-ийн гематурийн хэлбэр
- C. Архаг ГН-ийн холимог хэлбэр
- D. IgA нефропати
- E. Бержийн өвчин

/158./ Глюкокортикоид эмчилгээний гаж нөлөө юу вэ?

- 1. Иценго-Кушингийн хамшинж
- 2. Артерийн даралт ихдэх
- 3. Остеопороз
- 4. Гипергликеми
- 5. Хоёрдогч халдвар үүсэх

/159./ Архаг ГН-ийн шалтгаанд аль нь орох вэ?

- 1. Бөөрөнд халтай эм
- 2. Үрэвслийн эсрэг стероид бус эмийг удаан хэрэглэх
- 3. Халдварын архаг голомт
- 4. Вирүсийн халдвар
- 5. Ахуйн таагүй байдал

/160./ Бага насны хүүхдэд бөөр-шээсний замын халдвар үүсэхэд нөлөөлөх хүчин зүйл:

- 1. Энтеробиоз
- 2. Гаж хөгжил
- 3. Давсагны үйл ажиллагаа алдагдах
- 4. Баасан дээрээ удаан хэвтэх
- 5. Хөвгүүдийн тээрхийн нарийсал

/161./ Цочмог гломерулонефритийг бөөрний үйл ажиллагааны байдлаар нь хэрхэн ангилдаг вэ?

- 1. Бөөрний үйл алдагдаагүй
- 2. Бөөрний үйл алдагдсан
- 3. Бөөрний цочмог дутагдал
- 4. Бөөрний үйл бага зэрэг алдагдсан
- 5. Бөөрний архаг дутагдал

/162./ Пиелонефритийг аль өвчнүүдээс ялган оношилох вэ?

- 1. Тубулопати
- 2. Бөөрний сүрьеэ
- 3. Бөөрний амилоидоз
- 4. Гломерулонефрит
- 5. Бөөр-шээсний замын чулуу

/163./ Цочмог ГН-ийн үед

- 1. Эргэлдэгч ба бөөрний түүдгэнцэрт бэхлэгдсэн антиглобулин илэрнэ

2. Сийвэнгийн хавсарга СЗ буурна
  3. Сийвэнд фибриногений бүрдэл ихэснэ
  4. Бөөрний түүдгэнцэрт IgG СЗ-ын бөөгнөрөл илэрнэ
  5. Бөөрний түүдгэнцэрт хагас саран бөөгнөрөл харагдана
- /164./ Гломерулонефритийн үед минерал кортикоид-альдостероны үүсэлт хэрхэн идэвхждэг вэ?
1. Түүдгэнцрийн судасны анхдагч агчил болно
  2. Бие махбодод ус баригдаж шээс багасна
  3. Том судаснуудын баропрессорт үйлчилнэ
  4. Эсийн гаднах шингэн ихэснэ
  5. Цусанд кали ихэснэ
- /165./ Түргэн даамжрах ГН-ийн эмчилгээний аргуудыг сонгоно уу.
1. Стероид эм
  2. Азатиоприн
  3. Циклофосфамид
  4. Гепарин
  5. Дээр дурьдагдсан эмүүдийг янз бүрийн хувилбараар хослуулах
- /166./ Пиелонефритийн үндсэн хамшинжид аль нь орох вэ?
1. Өвдөлтийн хамшинж
  2. Дизурийн хамшинж
  3. Хордлогын хамшинж
  4. Цусархагшлын хамшинж
  5. Хавагнах хамшинж
- /167./ Шээс дамжуулах замын халдварт аль нь орох вэ?
1. Пиелонефрит
  2. Цистит
  3. Уретрит
  4. Гломерулонефрит
  5. Тубулопати
- /168./ Нефрогенный штаммд цус задлагч А-бүлгийн стерптококкийн ямар омгууд багтдаг вэ?
1. М4
  2. М12
  3. М18
  4. М25
  5. М49
- /169./ Бөөр-шээсний замын халдвартай хүүхдэд илэрч болох өөрчлөлтүүдийг сонгоно уу?
1. Лейкоцитоз, саармагсаг эс багасах, лимфоцитоз
  2. Пиури, шээсэнд нитрит эерэг байх
  3. Шээсэнд эмгэгтөрөгч 5000 илрэх
  4. Лейкоцитоз, саармагсаг эс ихсэх
  5. Аддисын сорилд лейкоцит 1 сая
- /170./ 13 настай хүүхдийн биед агуулагдах нийт төмрийн хэмжээ ямар вэ?
- A. 242 мг
  - B. 122 мг
  - C. 400 мг
  - D. 600 мг
  - E. 2600 мг
- /171./ Хүнд тураалтай хүүхдэд хоногт нэмж өгөх магнийн хэмжээ хэд вэ?
- A. 0.4-0.6 ммоль/кг
  - B. 1.0-2.0 ммоль/кг
  - C. 3.0-4.0 ммоль/кг
  - D. 5.0-6.0 ммоль/кг
  - E. 7.0-8.0 ммоль/кг
- /172./ Ямар үед макроцитар, гиперхром цус багадалт үүсэх вэ?
- A. Фолийн хүчлийн дутагдал

- B. B12-аминдэм дутах
- C. Төмөр дутах
- D. Уургийн дутагдал
- E. Д-аминдэмийн дутагдал

/173./ Кальци, фосфорын солилцоонд D-аминдэмийн аль хэлбэр илүү идэвхтэй нөлөөлөх вэ?

- 1. 25-гидрохолекальциферол
- 2. 1.25-дигидрохолекальциферол
- 3. 1.25-холекальциферол
- 4. 24,25-дигидрохолекальциферол
- 5. 25-дигидроксихолекальциферол

/174./ Бромгексины шахмалын тунг сонго

- 1. 2 мг шахмал
- 2. 4 мг шахмал
- 3. 6 мг шахмал
- 4. 8 мг шахмал
- 5. 10 мг шахмал

/175./ Тураалтай хүүхдэд гарч болох хүндрэлийг заана уу?

- 1. Рахит
- 2. Цус багадалт
- 3. Гипотерми
- 4. Халдвар
- 5. Цохиулалт

/176./ Тураалын I зэрэгт аль шинж тохирохгүй вэ?

- 1. Гэдэс цардгар
- 2. Амны салт тод ягаан өнгөтэй
- 3. Арьсан доорх өөхөн эд цээжинд арилсан
- 4. Биеийн жин 11-20% буурсан
- 5. Хэвлий орчим арьс үрчийнэ

/177./ Төмөр дутлын цус багадалтын үед ямар шинж илрэх вэ?

- 1. Ядрамтгай болох
- 2. Толгой өвдөх
- 3. Хэлний хөхлөг арилах
- 4. Өтгөн хатах
- 5. Элэг томрох

/178./ Тураалын урьдчилан сэргийлэлтэнд аль нь хамаарах вэ?

- 1. Халдвараас хамгаалах
- 2. Нэмэгдэл хоолонд цагт нь оруулах
- 3. Жирэмсний хяналтыг сайжруулах
- 4. Суурь өвчнийг цаг тухайд нь эмчлэх
- 5. Хүүхдийг 2 нас хүртэл хөхний сүүгээр хооллох

/179./ Рахитын ид үед шинжилгээнд ямар өөрчлөлт гарч болох вэ?

- 1. Шүлтлэг фосфатаз ихэснэ
- 2. Гипофосфатеми
- 3. Метаболик ацидоз
- 4. Анеми
- 5. Нормокальциеми

/180./ Дараахаас аль нь хүүхдийн тураалын шалтгаан болох вэ?

- 1. Хромосомын гажиг
- 2. Жирэмсэн эх өлсөх
- 3. Целиаки өвчин
- 4. Ургийн хүчилтөрөгчгүйдэл
- 5. Жирэмсэн эхийн хорт зуршил

/181./ 2 хүртэлх насны хүүхэд уушгины цочмог үрэвслээр эндэх шалтгаан юутай холбоотой вэ?

1. Уушгины завсрын эдийн хөгжил сул
  2. Цусны судсаар баялаг
  3. Хялгасан судас, тунгалгийн ховил өргөн
  4. Уян эд бүрэн хөгжөөгүй
  5. Цулцангийн хөгжил эрчимтэй явагдах
- /182./ Тураалтай маш сул дорой хүүхдэд тэжээлийн холимгийг ямар аргаар өгөх вэ?
1. Дусаагуур
  2. Халбага
  3. Тариур
  4. Угж
  5. Аяга
- /183./ Тураалын ангилалд аль нь тохирох вэ?
1. Хүнд
  2. Хоол тэжээлийн шалтгаантай
  3. Халдварын шалтгаантай
  4. Хоёрдогч
  5. Хожмын
- /184./ Ямар тохиолдолд хүүхдэд дотуур цус алдалт нэмэгдэх вэ?
1. Шүүдэст эмзэгшил
  2. Ходоод-гэдэсний үрэвсэлт өвчнүүд
  3. Хоолны харшил
  4. Гэдэсний шимэгч хорхой
  5. А-аминдэмийн дутагдал
- /185./ Сальбутамолыг цацлагаар хэрэглэх тохиолдолд хүүхдийн кг жинд хэдэн мг/кг-аар тооцох вэ?
- A. Биеийн нэг кг жинд 0.1 мг/кг
  - B. Биеийн нэг кг жинд 0.2 мг/кг
  - C. Биеийн нэг кг жинд 0.3 мг/кг
  - D. Биеийн нэг кг жинд 0.4 мг/кг
  - E. Биеийн нэг кг жинд 0.5 мг/кг
- /186./ Уушгины хөгжлийн I үе 0-2 насанд илрэх эмнэлзүйн онцлог
- A. Уушгины цочмог үрэвсэл сунжруу явцтай болох
  - B. Аливаа эмгэгийн үед уушги тэлэгдэх, шалчийх, хавагнаших нь амархан
  - C. Уушгины цочмог үрэвсэл хүндрэл багатай явагдаж бүрэн эдгэрэх
  - D. Уушгины үрэвсэл ихэвчлэн доод дэлбэнгийн 6, 10-р, дээд дэлбэнгийн 2-р хэлтэнд байрлах
  - E. Гуурс уушгины цэвэршилт муу явагдах
- /187./ Сальбутамолын 1 удаагийн хэрэглэх тун
- A. 3-5 мг
  - B. 4-5 мг
  - C. 1-2 мг
  - D. 0.2-0.3 мг
  - E. 0.3- 0.5 мг
